

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 04-ны өдөр

№ 12

Улаанбаатар хот

### *Гэрээ байгуулахыг зөвшөөрөх тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.13 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.26, 8.6.29 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн 9 дүгээр шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компани нь өөрийн охин компани болох Англи Улсад бүртгэлтэй Мон Ремит Лимитед /РД: 11821649/ компанийн хувьцааг худалдах, худалдан авах эрх олгох Опцион гэрээ, түүний хавсралт Хувьцаа худалдан авах гэрээг Англи улсын “Fibonacci Consulting Services Limited” компанитай энэхүү тогтоолын Хавсралт №1-г заасан нөхцөлөөр байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын 1-д дурдсан гэрээнүүдтэй холбоотой хэлэлцээ хийж, бусад нөхцөлүүдийг эцэслэн тохирч, тус гэрээнүүдийг байгуулах, гэрээнд гарын үсэг зурах, гэрээг хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д олгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



“Сэндли ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 03р сарын  
21-ний өдрийн 12 тоот тогтоолын Хавсралт №1



“СЭНДЛИ ББСБ” ХК, АНГЛИ УЛСЫН “FIBONACCI CONSULTING  
SERVICES LIMITED” КОМПАНИЙН ХООРОНД БАЙГУУЛАХ  
ОПЦИОН ГЭРЭЭ, ТҮҮНИЙ ХАВСРАЛТ ХУВЬЦАА  
ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН НӨХЦӨЛҮҮД

1. Опционыг хэрэгжүүлэх боломжтой хугацаанд (Interim period) Англи Улсын “Fibonacci Consulting Services Limited” компани (“Fibonacci”) нь сар бүр Англи Улсад бүртгэлтэй Мон Ремит Лимитед /РД: 11821649/ компани (“Мон Ремит”)-ийн 2,200 хүртэлх фунт стерлингийн зардлыг Опцион гэрээний дагуу төлнө;
2. Опцион болон Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний дагуу Fibonacci-ийн авч болох Мон Ремит компанийн хувьцааны тоо: нэг бүр нь 0.00001 фунт стерлингийн нэрлэсэн үнэ бүхий 200,000 ширхэг энгийн хувьцаа;
3. Опцион гэрээ болон Хувьцаа худалдан авах гэрээний дагуу Fibonacci нь Мон Ремитийн хувьцааг худалдан авсан нөхцөлд “Сэндли ББСБ” ХК (“Компани”)-д төлөх төлбөр: 50,000 фунт стерлинг + эргэлтийн хөрөнгө болон өр төлбөрийн зөрүү байна.
4. Опцион гэрээний дагуу Fibonacci-аас Команийн авч болох Мон Ремитийн хувьцааны тоо: Нэг бүр нь 0.00001 фунт стерлингийн нэрлэсэн үнэ бүхий 20,995 ширхэг энгийн хувьцаа;
5. Опцион гэрээний дагуу Компани нь Мон Ремитийн хувьцааг худалдан авсан нөхцөлд Fibonacci-д төлөх төлбөр: 20,000 фунт стерлинг;
6. Fibonacci-аас опционыг хэрэгжүүлэх боломжтой хугацаа: Опцион гэрээ байгуулснаас хойш 12 сарын хугацаанд;
7. “Сэндли ББСБ” ХК-аас опционыг хэрэгжүүлэх боломжтой хугацаа: Fibonacci-аас опционыг хэрэгжүүлэх боломжтой хугацаа дууссан ажлын өдрөөс эхлэн 30 хоногийн дотор.

— оОо —